

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Сум дундын Прокурорын газрын 2021 оны оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/236-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2022 он	Тэргүүлэх аудитор:	Ч.Энхтуяа
	Утас: 7036-3040	Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn
	Аудитын менежер:	Б.Батмөнх
	Утас: 7036-3036	Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn
	Аудитор:	Т.Одсүрэн
	Утас: 7036-2442	Цахим хаяг: odsurent@audit.gov.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Залруулсан алдаа.....	17
4.2 Зөвлөмж	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУЕП	Монгол Улсын Ерөнхий Прокурор
МУЕПГ	Монгол Улсын Ерөнхий Прокурорын газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.18 № СЭА-2022/236-НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Сум дундын Прокурорын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Сум дундын Прокурорын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	654,100.00	15,026,300.00
34	УРЬДЧИЛГАА	-	6,700,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	6,700,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	654,100.00	8,326,300.00
354	Хангамжийн материал	654,100.00	8,326,300.00
35410	Бичиг хэргийн материал	265,100.00	297,600.00
35420	Аж ахуйн материал	-	3,663,700.00
35440	Түлш, шатах тослох материал	260,000.00	140,000.00
35450	Барилгын засварын материал	129,000.00	4,225,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	372,805,512.53	415,214,763.61
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	372,805,512.53	415,214,763.61
392	Биет хөрөнгө	367,455,112.53	409,864,363.61
39201	Барилга, байгууламж, орон сууц	292,727,765.56	292,727,765.56
39202	Хуримтлагдсан элэгдэл	(9,145,198.20)	(14,023,994.40)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	86,224,333.52	86,224,333.52
39204	Хуримтлагдсан элэгдэл	(39,149,333.47)	(44,529,333.43)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	46,018,624.88	91,696,512.88
39206	Хуримтлагдсан элэгдэл	(18,755,074.68)	(26,411,272.98)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,993,669.08	34,793,669.08
39208	Хуримтлагдсан элэгдэл	(8,531,674.16)	(10,685,316.62)
39217	Ном	72,000.00	72,000.00
393	Биет бус хөрөнгө	5,350,400.00	5,350,400.00
39303	Бусад биет бус хөрөнгө	5,350,400.00	5,350,400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	373,459,612.53	430,241,063.61
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	373,459,612.53	430,241,063.61
51	Засгийн газрын хувь оролцоо	373,459,612.53	430,241,063.61
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	77,262,737.75	77,262,737.75
51101	Өмч: - төрийн	77,262,737.75	77,262,737.75
512	Хуримтлагдсан үр дүн	96,624,712.34	153,406,163.42
51210	Өмнөх үеийн үр дүн	96,624,712.34	96,624,712.34
51220	Тайлант үеийн үр дүн	-	56,781,451.08
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	199,572,162.44	199,572,162.44
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	373,459,612.53	430,241,063.61

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	380,223,219.39	550,318,288.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	36,352,619.39	45,526,988.00
120	Нийтлэг татварын бус орлого	36,352,619.39	45,526,988.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	36,352,579.39	42,547,988.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0	2,979,000.00

Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Сум дундын Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	343,870,600.00	504,791,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	343,870,600.00	504,791,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	343,870,600.00	504,791,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	375,770,821.44	493,536,836.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	375,770,821.44	493,536,836.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	369,310,395.76	482,205,723.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	252,217,519.51	340,693,394.71
210101	Үндсэн цалин	187,352,919.51	228,378,792.06
210102	Нэмэгдэл	57,760,600.00	105,210,602.65
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,104,000.00	7,104,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,705,788.81	41,768,200.00
210201	Тэтгэврийн даатгал	20,463,688.81	29,086,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,310,500.00	3,170,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,848,400.00	2,536,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	462,100.00	634,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,621,100.00	6,340,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,783,259.00	12,819,054.00
210301	Гэрэл, цахилгаан	1,851,225.00	2,108,946.00
210302	Түлш, халаалт	8,021,275.00	8,741,916.00
210303	Цэвэр, бохир ус	910,759.00	1,968,192.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,501,574.00	21,363,700.00
210401	Бичиг хэрэг	8,504,900.00	8,272,783.00
210402	Тээвэр, шатахуун	8,120,674.00	8,620,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,348,000.00	636,266.00
210404	Ном, хэвлэл	200,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,828,000.00	607,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	3,227,251.00
2105	Нормативт зардал	65,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	65,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,871,000.00	21,130,494.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,000,000.00	1,978,600.00
210604	Урсгал засвар	4,871,000.00	19,151,894.00
2107	Томилолт, зочны зардал	1,474,100.00	1,315,000.00
210702	Дотоод албан томилолт	1,474,100.00	1,315,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,828,135.00	8,932,444.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,545,500.00	7,301,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	191,500.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	897,175.00	897,175.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	159,800.00	161,689.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	522,500.00
210807	Газрын төлбөр	12,160.00	6,080.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,864,019.44	34,183,436.92
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	4,882,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,000,000.00	9,232,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	28,864,019.44	20,068,636.92
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,460,425.68	11,331,113.29
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,290,000.00	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,290,000.00	1,000,000.00

Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Сум дундын Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит			
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,170,425.68	10,331,113.29
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,170,425.68	10,331,113.29
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	4,452,397.95	56,781,451.08
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	4,452,397.95	56,781,451.08

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	696,649.58	696,649.58
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	77,262,737.75	199,572,162.44	96,624,712.34	373,459,612.53
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	77,262,737.75	199,572,162.44	96,624,712.34	373,459,612.53
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	77,262,737.75	199,572,162.44	96,624,712.34	373,459,612.53
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	56,781,451.08	56,781,451.08
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	77,262,737.75	199,572,162.44	153,406,163.42	430,241,063.61

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	343,870,600.00	504,791,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	343,870,600.00	504,791,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	343,870,600.00	504,791,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	343,870,600.00	504,791,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	343,870,600.00	484,861,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	343,870,600.00	484,861,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	337,410,174.32	473,530,286.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	250,765,891.51	340,693,394.71
210101	Үндсэн цалин	185,901,291.51	218,328,792.06
210102	Нэмэгдэл	57,760,600.00	115,260,602.65
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,104,000.00	7,104,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,705,788.81	41,768,200.00
210201	Тэтгэврийн даатгал	20,463,688.81	29,086,300.00

Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Сум дундын Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит			
210202	Тэтгэмжийн даатгал	2,310,500.00	3,170,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,848,400.00	2,536,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	462,100.00	634,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,621,100.00	6,340,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,783,259.00	12,819,054.00
210301	Гэрэл, цахилгаан	1,851,225.00	2,108,946.00
210302	Түлш, халаалт	8,021,275.00	8,741,916.00
210303	Цэвэр, бохир ус	910,759.00	1,968,192.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,788,000.00	20,684,200.00
210401	Бичиг хэрэг	8,100,000.00	8,305,283.00
210402	Тээвэр, шатахуун	7,460,000.00	7,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,700,000.00	636,266.00
210404	Ном, хэвлэл	200,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,828,000.00	684,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	3,558,051.00
2105	Нормативт зардал	65,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	65,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,000,000.00	25,517,994.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,000,000.00	2,270,100.00
210602	Тавилга	-	3,300,000.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	19,947,894.00
2107	Томилолт, зочны зардал	1,474,100.00	1,315,000.00
210702	Дотоод албан томилолт	1,474,100.00	1,315,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,828,135.00	10,441,444.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,545,500.00	8,810,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	191,500.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	897,175.00	897,175.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	159,800.00	161,689.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	522,500.00
210807	Газрын төлбөр	12,160.00	6,080.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,000,000.00	20,291,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	4,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,000,000.00	16,291,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,460,425.68	11,331,113.29
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,290,000.00	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,290,000.00	1,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,170,425.68	10,331,113.29
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,170,425.68	10,331,113.29
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	<u>19,929,900.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	<u>19,929,900.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	<u>19,929,900.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	-	19,929,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	19,929,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	<u>(19,929,900.00)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=

Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Сум дундын Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит					
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ				
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)				
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт/ хэмнэлт	хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	504,791,300.00	494,460,186.71	10,331,113.29	97.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	504,791,300.00	494,460,186.71	10,331,113.29	97.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	503,791,300.00	493,460,186.71	10,331,113.29	97.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	348,372,400.00	340,693,394.71	7,679,005.29	97.80
210101	Үндсэн цалин	231,194,300.00	218,328,792.06	12,865,507.94	94.44
210102	Нэмэгдэл	110,074,100.00	115,260,602.65	(5,186,502.65)	104.71
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,104,000.00	7,104,000.00	0.00	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,768,200.00	41,768,200.00	0.00	100.00
210201	Тэтгэврийн даатгал	29,086,300.00	29,086,300.00	0.00	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,170,500.00	3,170,500.00	0.00	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,536,400.00	2,536,400.00	0.00	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	634,100.00	634,100.00	0.00	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,340,900.00	6,340,900.00	0.00	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,824,700.00	12,819,054.00	5,646.00	99.96
210301	Гэрэл, цахилгаан	2,000,000.00	2,108,946.00	(108,946.00)	105.45
210302	Түлш, халаалт	8,745,100.00	8,741,916.00	3,184.00	99.96
210303	Цэвэр, бохир ус	2,079,600.00	1,968,192.00	111,408.00	94.64
2104	Хангамж, бараа материалын зардал	20,684,200.00	20,684,200.00	0.00	100.00
210401	Бичиг хэрэг	8,175,000.00	8,305,283.00	(130,283.00)	101.59
210402	Тээвэр, шатахуун	7,500,000.00	7,500,000.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	800,000.00	636,266.00	163,734.00	79.53
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	800,000.00	684,600.00	115,400.00	85.58
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,000,000.00	3,558,051.00	(558,051.00)	118.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	45,448,300.00	45,447,894.00	406.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,500,000.00	11,500,000.00	0.00	100.00
210602	Тавилга	14,000,000.00	14,000,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	19,948,300.00	19,947,894.00	406.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	1,315,000.00	1,315,000.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	1,315,000.00	1,315,000.00	0.00	100.00

Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Сум дундын Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,087,500.00	10,441,444.00	2,646,056.00	79.78
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,400,000.00	8,810,000.00	2,590,000.00	77.28
210803	Даатгалын үйлчилгээ	897,200.00	897,175.00	25.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	185,200.00	161,689.00	23,511.00	87.31
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	555,000.00	522,500.00	32,500.00	94.14
210807	Газрын төлбөр	6,100.00	6,080.00	20.00	99.67
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,291,000.00	20,291,000.00	0.00	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,000,000.00	4,000,000.00	0.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,291,000.00	16,291,000.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	504,791,300.00	494,460,186.71	10,331,113.29	97.95
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	504,791,300.00	494,460,186.71	10,331,113.29	97.95
310001	Улсын төсвөөс санхүүжих	504,791,300.00	494,460,186.71	10,331,113.29	97.95
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	17.00	16.00	1.00	94.12
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	8.00	7.00	1.00	87.50
620003	Үйлчлэх ажилтан	8.00	8	0.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	17.00	16.00	1.00	94.12
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	3.00	3	0.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8.00	8	0.00	100.00
650012	Шүүгч, прокурор	6.00	5.00	1.00	83.33

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Сум дундын Прокурорын газар /цаашид Мандал сум дахь Сум дундын Прокурорын газар гэх/-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн төрийн үйлчилгээний албан албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох, жолоочийн тооцооны хуудсанд явсан км-ыг бодитоор бүртгээгүй болон төлбөрийн цахим баримттай холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Одсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мандал сум дахь Сум дундын Прокурорын газар 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 1/102 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.


3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Мандал сум дахь Сум дундын Прокурорын газрын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Мандал сум дахь Сум дундын Прокурорын газар нь *Хууль тогтоох байгууллагын бодлогын үзэл санааг тууштай дэмжиж, хяналтын ажлын чанар үр нөлөөг дээшлүүлэх, зон олны эрх, эрх чөлөө, эд баялаг, түүхт уламжлалыг сахин хамгаалж, хууль тогтоомжийг төрийн нэрийн өмнөөс хэрэгжүүлэх*” гэсэн эрхэм зорилготойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Тус газар нь 2021 онд баримтлах үйл ажиллагааны зорилт, чиглэлээ дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- *Байгууллагын үйл ажиллагаанд инновац нэвтрүүлэх,*
- *Гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах,*
- *Прокурор, ажилтны ажлын ачааллыг тэнцвэржүүлэх,*
- *Чадварлаг прокурор, ажилтныг сайшаан дэмжих,*
- *Прокурор, ажилтны суралцах орчин, нөхцөлийг бүрдүүлэх,*



Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Мандал сум дахь Сум дундын Прокурорын газрын үйл ажиллагаанд МУЕПГ-ын Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын хэлтсээс хяналт тавьж ажилладаг бөгөөд тайлант онд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлэх, хууль хэрэгжүүлэн ажиллах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах зөвлөмж хүргүүлснийг, хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг тогтоосон хугацаанд явуулсан байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сум дахь Сум дундын Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл/мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 374,119.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 3,741.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,618.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн болно.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мандал сум дахь Сум дундын Прокурорын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос **56,781.5** мянган төгрөгөөр буюу **15.2** хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урьдчилгаа	-	6,700.00	6,700.00
Бараа материал	654.10	8,326.30	7,672.20
Үндсэн хөрөнгө	372,805.50	415,214.80	42,409.30
Нийт хөрөнгө	373,459.60	430,241.10	56,781.50
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	373,459.60	430,241.10	56,781.50
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	373,459.60	430,241.10	56,781.50

Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэл 6,700.0 мянган төгрөг болсон нь төлөвлөсөн сургалтыг тайлант онд багтаан зохион байгуулж амжилгүйгээр сургалтын төлбөрийг гэрээт харилцагчид урьдчилан шилжүүлсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 8,326.3 мянган төгрөг болж 7,672.2 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 57,042.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан болон МУПЕГ-аас 2,979.0 мянган төгрөгийн бараа материал шилжүүлэн авч, 52,349.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 510,864.7 мянган төгрөг болж 62,477.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 19,929.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл худалдан авсан болон МУЕПГ-аас, 32,548.0 мянган төгрөгийн техник, тоног төхөөрөмж, Мандал сумын Засаг даргын 2021 оны А/226 дугаар захирамжаар 10,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 430,241.1 мянган төгрөг болж 56,781.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг тус бүр 311,502.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг урсгал зардлыг 91,109.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 402,611.9 мянган төгрөгөөр баталсан байна.

МУЕПГ-аас батлагдсан төсөвт 2021 оны 3, 10 дугаар сард өөрчлөлт оруулж, унаа хоолны хөнгөлөлт, онцгой нөхцөлийн нэмэгдэл, шинээр 4 орон тоо нэмэгдсэн, болон тус газрын 60 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотойгоор цалин, хөлс болон НДШ-ийн зардлыг 33,456.6 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 44,548.3 мянган төгрөгөөр, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 20,191.0 мянган төгрөгөөр, бусад зардлыг 3,983.5 мянган төгрөгөөр зэрэг нийт зардлыг 102,179.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр **504,791.3 мянган** төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **494,460.2** мянган төгрөг буюу 97.9 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 7,679.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 2,646.0 мянган төгрөгөөр, бусад зардлыг 6.1 мянган төгрөг зэрэг нийт зардлыг 10,331.1 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар тайлант онд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

3.7.1 МУЕПГ-аас тус газрын төсөвт 2021 оны 10 дугаар сард хийгдсэн өөрчлөлтөөр буюу төсвийн жилийн эцэст хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 14,291.0 мянган төгрөгөөр, тавилга, багаж техник хэрэгсэл худалдан авах зардлыг 23,000.0 мянган төгрөгөөр, урсгал засварын зардлыг 14,375.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн төсвийн зохицуулалт хийсэн байна.

Энэ нь төсвийг төсвийн жилийн хугацаанд багтаан зарцуулах цаг хугацааны хязгаарлагдмал байдал үүсгэх, үүнээс шалтгаалан авлага үүсгэх эрсдэлийг үүсгэснээс төлөвлөсөн сургалтыг тайлант онд багтаан зохион байгуулж амжилгүйгээр 6,700.0 мянган төгрөгийг гэрээт харилцагчид шилжүүлж, урьдчилж гарсан зардлаар тайлагнаж, авлага үүсгэсэн байна. Цаашид гэрээт ажлыг тухайн төсвийн жилд багтаан хэрэгжүүлэх боломжтой хугацаанд нь тооцож, төсөвт зохицуулалт хийж, санхүүжилтийг шийдвэрлэж байх нь зүйтэй юм.

3.7.2 МУЕП-ын 2021 оны А/176 дүгээр тушаалаар тус газрын нягтлан бодогчид 1 сарын үндсэн цалингийн 60 хувьтай тэнцэх хэмжээний буюу 478.6 мянган төгрөгийн урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан буюу тогтоосон хэмжээг хэтрүүлэн олгох шийдвэр гаргаж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх “Улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 3 дугаар хавсралтын 2.2-т “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна.” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд тухайн албан тушаалтнууд холбогдох хууль эрхийн актын дагуу улирал бүр ажлын үр дүнгээ үнэлүүлж, мөнгөн урамшуулал авч байхад санхүүгийн тайлангаар “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан, санхүүгийн үйл ажиллагаа сайн гэх үндэслэлээр буюу ажлын үр дүнгийн зөвхөн 1 үзүүлэлтийг үндэслэн урамшууллыг давхардуулан олгох шийдвэрийг төсвийн ерөнхийлөн захирагчийн зүгээс гаргахгүй байх нь зүйтэй юм.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Мандал сум дахь Сум дундын Прокурорын газрын мэдээлбэл зохих 20 төрлийн 149 мэдээллээс 148 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн бол 1 мэдээлэл /Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр (Тухай бүр) гэсэн мэдээллийг 9 дүгээр сард /-ийг 1 удаа хугацаа хоцроон мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3,389.2 мянган төгрөгийн зөрчил арилгах 1 албан шаардлага, 3 зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна

Хүснэгт 2: Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	3,389.2	1	3,389.2	-	-	100.0
Зөвлөмж	3	-	3	-	-	-	100.0
Нийт дүн	4	3,389.2	4	3,389.2	-	-	100.0

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

3.11.1 Тайлант онд төлбөрийн баримтын цахим системд шивэгдсэн нийт 80,295.9 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтад тус байгууллагын ажилчдын хувийн болон бусад аж ахуйн нэгжүүдийн давхардуулан шивсэн 10,433.2 мянган төгрөгийн худалдан авалт орж шивэгдсэн байгаа нь анхан шатны баримтгүй болон баримтын бүрдэлгүй орлого зарлагын гүйлгээг хүлээн зөвшөөрч данс бүртгэлд тусгах эрсдэлийг үүсгэж байна. Иймд төлбөрийн баримтын цахим системийг үнэн зөв хөтлөх, алдаатай эсвэл буруу шивэгдсэн баримтуудыг тухай бүр залруулж байх шаардлагатай байна.

3.11.2 Харилцагч талуудын хооронд гарсан ажил гүйлгээний тооцооны үлдэгдлийг тайлант үеийн эцэст тооцоо үүссэн данс тус бүрээр хөтөлж, батлаагүй, 2 байгууллагын тооцооны баримтыг тооцооны үлдэгдлийн баталгааны хавсралтад нэгтгэж гаргаагүй байна. Иймд жилийн эцсийн тооцоо нийлсэн актыг баталгаажуулахдаа дээрх зөрчлүүдийг арилгах нь зүйтэй юм.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 153,027.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 117,914.9 мянган төгрөгийн алдааг залруулж 35,112.4 мянган төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмж өгөгдлөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Урьдчилж гарсан 97,750.0 мянган төгрөгийн цалинг цалингийн урьдчилгаа дансаар дамжуулалгүй цалингийн зардал дансанд бүртгэсэн. 4317143998
- Мандал сумын ЗДТГ-аас үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 10,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн тодруулгын тайланд ангилал буруу бүртгэсэн.
- Үндсэн хөрөнгийн дансанд шинээр орлого авсан 2,199.0 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглалтын жилийг оруулаагүй болон 3,300 мянган төгрөгийн бараа материалыг хөрөнгөөр бүртгэж нийт 164.9 мянган төгрөгийн хөрөнгийн элэгдэл зөрүүтэй байгуулсан.
- Үндсэн хөрөнгийн шинж чанаргүй 3,300.0 мянган төгрөгийн барилгын материалыг үндсэн хөрөнгөд бүртгэсэн,
- Гэрээт ажил буюу сургалт зохион байгуулагдаагүй байхад хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлын 6,700.0 мянган төгрөгийг урьдчилан шилжүүлж, зарлагаар тайлагнасныг урьдчилж төлсөн зардлаар бүртгэж, залруулав.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

1.1.1 *Илрүүлэлт:* Тайлант онд 31,283.8 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтыг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасныг зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.1.2 *Өгсөн зөвлөмж:* Цаашид төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

1.2.1 Илрүүлэлт: Жолоочийн тооцооны хуудсанд явсан чиглэл, хугацааг тодорхой бичээгүй, ижил чиглэл хоорондын зайг зөрүүтэй бүртгэсэн зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр **2,978.6** мянган төгрөгийн шатахууныг зарцуулж, тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2.2 Өгсөн зөвлөмж: Жолоочийн тооцооны хуудсанд явсан км, чиглэлийг тодорхойлсон замнал / маршрут / үйлдэж хавсаргах, шатахууны зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

2. Нэмэгдэл цалинтай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын үзүүлэлтийг шалгуур үзүүлэлтийн дагуу улирлаар дүгнэлгүйгээр сар бүр ур чадварын нэмэгдэл олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журмын 3-д "Төрийн үйлчилгээний байгууллагын... албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу ... тооцож, сар бүр олгоно", Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох журам"-ын 5-д "Ажилтанд олгож байгаа ур чадварын нэмэгдлийг заасан хязгаарт багтаан нэмэгдүүлэх, бууруулах асуудлыг улирал бүр хэлэлцэн шийдвэрлэж байна" гэж заасныг зөрчсөн ба "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж Төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгохдоо шалгуур үзүүлэлтийн дагуу улирлаар дүгнэж, сар бүр олгож байх.

3. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал


3.1 Илрүүлэлт: Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлыг төсөвлөсөн боловч тухайн зардлын зүйлд төсөв батлагдаагүйгээс ажлын хувцас худалдан авах **850.0** мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас хийж гүйцэтгэсэн байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална", 5.1.2 дахь "Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж

Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Сум дундын Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит мэдэгдлийг зөрчиж байгаа тул төсвийн зардлыг бодитоор, үнэн зөв төлөвлөж, хэрэгжүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Мандал сум дахь Сум дундын Прокурорын газар	9	153,027.3	5	117,914.9					4	35,112.4
	Нийт	9	153,027.3	5	117,914.9					4	35,112.4